

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 74 ДҮГЭЭР ЗҮЙЛ
"ХОРИХ ЯЛ ЭДЛЭХЭЭС ХУГАЦААНААС ӨМНӨ ТЭНСЭН СУЛЛАХ", ЭРҮҮГИЙН
БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 334 ДҮГЭЭР ЗҮЙЛ "ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ
СУЛЛАХ ЭДЛЭЭГҮЙ ҮЛДСЭН ЯЛЫГ ӨӨР ТӨРЛИЙН ХӨНГӨН ЯЛААР СОЛИХ
ТУХАЙ ЗААЛТУУДЫГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ НЭГ МӨР ОЙЛГОХ ТУХАЙ**

/ЗӨВЛӨМЖ/

2004 оны 2 сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү зөвлөмж нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Эрүүгийн хуулийг тайлбарлах хэмжээээр биш дээрх зүйлд заасан шүүхийн үйл ажиллагаанд анхаарвал зохих зүйлүүдийн талаар дурьдсан болно.

Монгол Улсын Эрүүгийн шинэ хуульд хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай хэм хэмжээг өмнөх хуулийн ижип төстэй заалтаас илүү өргөн хязгаарлалт багатай тогтоосон билээ.

1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих журмыг зарим онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд болон онц аюултай гэмт хэрэгтэн, төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдүүдэд хэрэглэхгүй байхаар тогтоосон бол Эрүүгийн шинэ хуульд ийм хязгаарлалтыг үндсэндээ багасган зөвхөн цаазаар авах ял шийтгүүж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд хэрэглэхгүй байхаар тогтоосон билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйл болон Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийг шүүхийн практикт нэг мөр зөв хэрэглэх үүднээс дор дурьдсан асуудалд Та нөхдийн анхаарлыг хандуулж байна.

НЭГ: Эрүүгийн байцаан шийтгэх хууль /шинэ/-ийн 334 дүгээр зүйлийн талаар:

1. Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлд заасан болзол шаардлага хангаж, хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллуулахаар гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гарсан Прокурорын дүгнэлт зэрэг нь шүүхэд энэ асуудлыг хэлэлцэх анхны баримт бичиг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтонд тухайн ялтны ял шийтгэлийн байдал, хөдөлмөрт хандах хандлага, зан төлвийн талаар тодорхойлон зааж ямар шалгуур үзүүлэлтээр засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан тухай тодорхойлон дурьдаж урьдах ял шийтгэлийн байдлыг нэг бүрчлэн шүүхийн шийтгэх /таслан шийдвэрлэх/ тогтоолд дурьдсан хэмжээгээр нэрлэн заах ба сүүлчийн ял шийтгүүлсэн хэргийн утга ял шийтгүүлсэн он сар өдөр, хуулийн зүйл хэсэг, хорих ялын хэмжээ, хорих ял эдэлж байхдаа авсан урамшуулал, хүлээсэн сахилгын шийтгэл, түүнийг хугацаанаас нь өмнө арилгасан тухай /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126, 127 дугаар зүйлийг үз/ нэг бүрчлэн зааж тэмдэглэсэн байх ёстой.

Энэ тодорхойлолтонд тухайн ялтны биечлэн эдэлсэн болон шагналын хоног, өршөөлөөр хасагдсан хугацаа зэргийг жил, сар, өдрөөр тус тусад нь ялган бичиж нэгтгэн, эдлээгүй үлдсэн хорих ялыг мөн дээрх байдлаар тодорхойлно.

Ялтны хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах тухай тодорхойлолт саналыг хорих ангийн дарга тухайн хорих ангийн нутаг дэвсгэрийн харъяалах прокурорт ялтны хувийн хэргийн хамт хүргүүлэх ба прокурор материалыг хянаж саналыг дэмжиж дүгнэлт гаргавал тухайн сум, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчид ялтны хувийн хэрэг хорих байгууллагын тодорхойлолт санапыг дүгнэлтийн хамт хүргүүлнэ.

2. Хувийн хэрэг материалыг хүлээн авсан сум дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч хувийн хэрэгт байгаа бүхий л бичиг баримттай нэг бүрчлэн танилцаж, хорих ангийн даргын санал, прокурорын дүгнэлт хэр үндэстэйг нарийвчлан хянаж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлийн 334.4 дэх хэсэгт заасан үндэслэлүүдийг харгалзан шийдвэрлэнэ.

3. Хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах тухай шүүхэд ирүүлэх баримт бичиг нь ялтны талаар гарсан хорих ангийн даргын тодорхойлолт /санал/ ялтны эдэлсэн ялын тооцоо, прокурорын дүгнэлт зэрэг баримт бичгүүдээс бүрдэх ба оногдуулсан ял шийтгэлийн болон бусад ач холбогдол бүхий үйл баримтын талаар ямар нэг эргэлзээ төрөхүйц байдал илэрвэл үүнтэй холбоотой нэмэлт баримт бичгийг хорих ангиас шүүгч шаардан авч болох боловч ялтан тус бүрийн тодорхойлолтонд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн тогтоол, магадлалын хуулбар, сахилгын шийтгэл оногдуулсан болон түүнийг арилгасан тухай тушаал шийдвэрүүдийн хуулбар хувийг хавсаргах шаардлагагүй гэж үзнэ.

Дээр дурьдсан бүхий л баримт бичиг ялтны хувийн хэрэгт нэг бүрчлэн байдаг бөгөөд шүүгч эдгээр баримт бичигтэй ширхэгчлэн танилцаж судлан үнэлэлт өгч дүгнэлт хийсний эцэст шүүх хуралдаанаар хэлэлцсэн байх учиртай.

Шүүгчийн захирамжинд тухайн ялтны биеийн байцаалт, ялангуяа ял шийтгэлийн байдлыг маш тодорхой тусгахын гадна түүний үйлдсэн хэргийн товч агууллага, эдэлсэн ялын тооцоог / биечлэн эдэлсэн, олгосон шагналын хоногоор/ тус тусад нь зааж үүнийг нэгтгэн хорих ял эдэлсэн бүх хугацааг жил, сар, хоногоор тооцон гаргаж эдлээгүй үлдсэн хугацааг тогтоон шийдвэрлэсэн байвал зохино.

Жич дурьдахад: Тухайн ялтны эдэлвэл зохих ялаас өршөөлийн хуулиар хасагдсан хугацаа нь түүний биечлэн эдэлсэн ялд орохгүй ба нийт эдлэх ялаас нь хасч үлдэх хугацааг нь Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэгт заасан хувиар тооцон шийдвэрлэнэ.

ХОЁР: Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн талаар:

1. Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт "хорих ял шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болно" гэж заасан байна.

Эрүүгийн шинэ хуулийн дээрх заалт нь тухайн ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах гол үндэслэл тул түүний "засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан байх" нь үндсэн шалгуур болзоп гэж ойлгох ёстой. Энэ болзол шалгуур нь ял эдлэх хугацаандаа хэдэн удаа урамшил шагнал авсан хөдөлмөрт хэрхэн ханддаг, үйлдсэн хэрэгтээ хэрхэн гэмшиж гэм буруугаа ойлгож байгаа, хамт хорих ял эдэлж буй хүмүүстэйгээ харилцаж байгаа байдал, тэдэнд сайн талын нөлөө хэр үзүүлдэг зэрэг түүний зан төлөвийн эерэг хүнлэг байдалд өгөх үнэлгээгээр илрэхийн гадна үйлдсэн хэргийнхээ улмаас бусдад учруулсан хохирлоо төлсөн байх шаардлага юм.

Харин "гэм хор" гэдэг нь материаллаг болон материаллаг бус хор уршиг, хохирол төлбөртэй хамаарах өргөн ойлголт бөгөөд хүнийг санаатай алсан, хүний аль нэг эрхтнээс нь салгаж хүнд гэмтэл учруулсан зэрэг хэрэгт дээр дурьдсан "гэм хорыг арилгасан тухай" ойлголт байхгүй тул үүнд гол төлөв "материаллаг хохирол"-ыг арилгасан эсэхтэй холбож ойлгох нь зүйтэй,

2. Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэгт ялтны үйлдсэн хэргийн ангиллаар оногдуулсан ялын тодорхой хувийг эдэлсний дараа "тэнсэн суллах" эсэх

асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр тогтоосон тул холбогдох материалыг хүлээн авсан шүүгч тухайн ялтны хорих ял шийтгүүлсэн хэрэг нь Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан хэргийн аль ангилалд багтаж байгааг юуны урьд тогтоох ёстой юм. Энэ ажиллагааг хийхдээ доорх байдлуудыг сайтар анхаарч дүгнэлт хийвэл зохино.

Тухайн ялтан хэд хэдэн гэмт хэрэг үйлдэж нэг шийтгэх тогтоолоор ял шийтгүүлсэн тохиолдолд тэдгээр хэргүүдийн хамгийн хүнд ангилалд хамаарах хэргийн хуульд заасан хувиар тэнсэн суллах эсэх тухай асуудлыг тооцон хэлэлцэх ёстой. Мөн ялтан хүнд эсвэл онц хүнд хэргүүдийн аль нэгэнд ял шийтгүүлэн уг ялыг эдэлж байхдаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж дахин ял шийтгүүлж Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлд заасан үндэслэлээр ял оногдуулсан бол урьдах тогтоолоор ял эдэлж байсан хүнд, онц хүнд хэргийн /Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.2 болон 74.3.3-д заасан/ хувиар тооцон үзэх ёстой гэж ойлгох нь зүйтэй.

3. Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-д тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй байх үндэслэлүүдийг заасан бөгөөд энэ нь тодорхой заалт ойлголт тул чандлан баримталвал зохино.

Харин 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд учруулсан "хохирлоо нөхөн төлөөгүй" тохиолдолд тэнсэн суллах эсэх тухай асуудалд хязгаар тавиагүй байсан юм.

2002 оны 9 дүгээр сарын 01-нээс өмнө хорих ял шийтгүүлсэн этгээдийг хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах үндэслэл байвал Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсэгт заасан хязгаарлалтанд хамааруулж "гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй" гэж үзэн хорих байгууллагын тодорхойлолт /санал/ прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгохгүй. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэ/-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт "...гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй" гэсэн заалтыг удирдлага болгох ёстой.

4. Эрүүгийн хууль /2002 оны/-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт "... гэм хорыг арилгасан бол..." гэж байгаа боловч мөн зүйлийн 74,4-д зөвхөн "гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо төлөөгүй" гэж тодорхойлон заасныг анхаарах нь зүйтэй.

5. Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002 оны/-ийн энэхүү харилцааг зохицуулж буй зүйлүүдэд байгаа доорх байдлыг ойлгох нь зүйтэй. Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйл нь "...Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах" тухай заасан бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлд "Япаас хугацааны өмнө суллах, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих" шүүхийн ажиллагааны талаар заасан байна. Эрүүгийн хуулийн дээрх зүйлд "Эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих" тухай заалтгүй тул зөвхөн Эрүүгийн хуулийн дээрх зүйлийн "хугацаанаас нь өмнө тэнсэн суллах" журмыг баримтлан шийдвэрлэх бөгөөд "эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай" шийдвэр гаргахгүй гэж ойлговол зохино.

Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлүүдийг шүүхийн практикт хэрэглэхэд гарч буй ойлгомжгүй, эсвэл бэрхшээлтэй асуудал гарвал энэ тухай Эрүүгийн хэргийн танхимд мэдэгдэж нэгдсэн ойлголттой болох талаар саналаа ирүүлэхийг хусье.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЭРҮҮГИЙН
ХЭРГИЙН ТАНХИМ